

“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 24-дөр

№ 09/2024



Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга сонгох, нарийн бичгийн дарга томилох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 80 дугаар зүйл, 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, “Түмэн шувуут” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 10.1, 13.1 дэх хэсэг, санал хураалтын дүн, хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Л.Эрхэмбаярыг сонгосугай.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргаар Д.Наранцэцэгийг томилсугай.
3. Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.
4. ТУЗ-ийн дарга болон нарийн бичгийн даргын танилцуулгыг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаст байрлуулж, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, олон нийтэд мэдээлэх, ТУЗ-ын нарийн бичгийн даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

	Л.ЭРХЭМБАЯР
	Б.ТУНГАЛАГ
	Ж.БОЛД
	Э.БАЯРЖАРГАЛ
	А.БАКЕЙ
	М.БОЛОД
	Ц.НАРАН-УЧРАЛ
	Г.МӨНХ-ЭРДЭНЭ
	О.ӨРГИЛ-ЭРДЭНЭ